31	Утааны хийн хэмжилтийн дадлага (2011 он - 2012 оны өвөл)	Үр дүн 2
32	ЖАЙКА бүсчилсэн нутгийн сургалт “УБ хотын автомашинаас үүдэлтэй орчны бохирдлын эсрэг авах арга хэмжээ” –ний сургалтын follow-up семинар (илтгэл)	Үр дүн 1
33	УХЗ-ны сайн болон муу ажиллагааны тухай семинар (анхны)	Үр дүн 4
34	Төслийн үйл ажиллагааны танилцуулга семинар (анхны)	Үр дүн 5
35	УХЗ-ны утааны хийн хэмжилт болон АБ-ын байдлыг урьдчилан тооцоолох тархалтын загварчлалтай холбогдуулсан зөвлөлдөх хуралдаан	Үр дүн 1, 2
36	Эх үүсвэрийн инвентор, тархалтын загварчлалын сургалт	Үр дүн 1
37	ЭХДХ-ийн оношлогооны багаж хэрэгслийг ашиглах тухай ажил хэргийн хуралдаан	Үр дүн 4
38	Төслийн үйл ажиллагааны танилцуулга семинар (2 дах удаа)	Үр дүн 5
39	ЭХДХ-ийн нарийвчилсан оношлогооны сургалт (4 дэх удаа)	Үр дүн 4
40	Зуухны галчын сургалт (1 дэх удаа) (2012 он - 2013 оны өвөл)	Үр дүн 3, 4
41	УХЗ-ны сайн болон муу ажиллагааны тухай семинар (2 дах удаа)	Үр дүн 4
42	Зуухны бүртгэл хяналтын мэдээллийн сангийн сургалт	Үр дүн 3
43	Зуухны галчын сургалт (2 дах удаа) (2012 он – 2013 оны өвөл)	Үр дүн 3, 4
44	Зуухны галчын сургалт (3 дах удаа) (2012 он - 2013 оны өвөл)	Үр дүн 3, 4
45	Япон дах байгаль орчны хяналт, удирдлагын менежментийн сургалт (Төслийн 3 дах жилийн)	Үр дүн 4, 5
46	Нэгдсэн семинар	Үр дүн 1~5

Төслөөс гарах үр дүн болон төслийн зорилгын харилцан холбоог Зураг 1.1-2-т үзүүлэв.



Зураг 1.1-2 Төслийн үр дүн болон зорилгын холбоо

Төслийн зорилгодоо хүрч, үр дүн гарахад чиглэсэн үйл ажиллагааны талаар дараах хэсэгт тайлбарлана.

1.1.2.1 Агаар бохирдуулах эх үүсвэрийн дүн шинжилгээ, агаар орчны үнэлгээний чадавхийг эзэмшүүлэх (Үр дүн-1)-тэй холбогдуулсан үйл ажиллагаа

Агаар бохирдуулах эх үүсвэрийн дүн шинжилгээ, агаар орчны үнэлгээний чадавхийг бий болгоход чиглэсэн үйл ажиллагаа нь суурин болон хөдөлгөөнт эх үүсвэрийн инвентор, бусад эх үүсвэрийн инвенторын өгөгдлийг боловсруулж шинэчлэх, тархалтын загварчлалын моделийг боловсруулж гаргах, түүнийг үйл ажиллагаанд ашиглах зэрэг байсан юм.

Төслийн хүрээнд Х/Т болон Х/Т-АХ-т эх үүсвэрийн инвенторын шинэчлэл, тархалтын загварчлалын моделийг гаргаж сурах техникийн ур чадавхийг эзэмшүүлэх тал дээр ажиллаж ирсэн бөгөөд шаардлагатай техникийн ур чадавхийг НАЧА, УАЧМА, ЦУОШГ, БОХЗТЛ-ын мэргэжилтнүүдийг хамруулан эзэмшүүлсэн болно.

Эх үүсвэрийн инвенторын хувьд эхний удаагийн суурь оны инвентор болгож 2010 оны хувилбарыг боловсруулсан. Төслийн хүрээнд хэрэгжүүлсэн утааны хийн хэмжилтийн дүн, зуухны бүртгэлийн өгөгдөл болон цуглуулсан мэдээллийн дүнг тусгасан 2010 оны шинэчилсэн хувилбар болон 2011 оны шинэчилсэн хувилбараар инвенторыг боловсруулж гаргасан. Техникийн ур чадавхи эзэмшүүлэх тал дээр Х/Т-АХ-ийн гишүүдэд эх үүсвэрийн инвенторыг шинэчлэхэд хялбар болгох үүднээс эх үүсвэрийн инвенторын систем болон техникийн гарын авлагыг боловсруулж гаргасан.

Эх үүсвэрийн инвентор болон тархалтын загварчлалын талаар жилийн ажлын тайланд 2 удаа тайлагнаж мэдээлсэн.

Мөн эх үүсвэрийн инвентор болон тархалтын загварчлалын моделийг ашиглан эх үүсвэр тус бүрт нэн тэргүүнд авах шаардлагатай арга хэмжээг судлахтай холбогдсон чадавхийг эзэмшүүлсэн.

1.1.2.2 Утааны хийн хэмжилт (Үр дүн-2)-тэй холбогдуулсан үйл ажиллагаа

X/T болон X/T-АХ-ийн гишүүд нь ДЦС-ын зуух болон УХЗ-ны утааны хийн хэмжилт хийж чадахуйц түвшинд техникийн ур чадавхийг эзэмшүүлсэн бөгөөд тус үйл ажиллагаанд НАЧА, УАЧМА, БОХТЛ, ДЦС II, ДЦС III, ДЦС IV мэргэжилтнүүдийг хамруулсан юм.

Сургалтын агуулгын хувьд үндсэн онол, механик болон автомат ажиллагаатай багаж төхөөрөмжийг ажиллуулах, химийн анализ шинжилгээ (SOx, NOx), хэмжилтийн ажил, өгөгдлийн боловсруулалт, тайлан боловсруулалт болон гарын авлага, заварчилгааг боловсруулах зэрэг ажлуудыг багтаасан.

Хэмжилтийн арга нь Олон Улсын Стандартчлалын Байгууллага (ОУСБ буюу ISO) болон JIS буюу Японы аж үйлдвэрлэлийн стандартын аргачлалд түшиглэн, МУ-ын цаг уурын нөхцөл байдал, нүүрс түлдэг зуухны шаталтын байдал зэрэгт зохицуулан сайжруулах шаардлагатай бөгөөд төслийн хүрээнд хэмжилтийн аргад тохирсон хэмжилтийн багаж төхөөрөмж (2 иж бүрдэл)-ийг нийлүүлсэн болно.

Утааны хийн хэмжилтийн дүнг төсөл хэрэгжилтийн хугацаанд 2 удаа НАЧА-ны жилийн ажлын тайланд оруулж тайлагнасан. Мөн хэмжилтийн тэмдэглэл, хэмжилтийн сорьцын цэг суурилуулах зааварчилгаа, химийн анализ шинжилгээний зааварчилгаа болон зуухны утааны хийн хэмжилтийн ажиллагааны гарын авлагыг боловсруулж гаргасан.

Зуухны ажиллагааны хяналт шинжилгээний ажлыг хийхээр төлөвлөж байсан хэдий ч НАЧА-ны ажил үүргийн эрх мэдлийн хүрээ болон бусад байгууллагатай хамтран ажиллах уялдаа холбооны асуудлаас хамааран 2012 оны 12 сарын байдлаар хяналт шинжилгээний ажил хийгдээгүй байгаа юм.

Хялбаршуулсан хэмжилтийн аргыг судалж үзэж байгаа боловч ялангуяа тоосны хялбаршуулсан хэмжилтийн аргын хувьд төсөл хэрэгжилтийн хугацаанд зохистой аргыг олж чадаагүй юм.

1.1.2.3 Ялгарлыг хэм хэмжээг журамлах НАЧА-ны хяналтын чадавхийг сайжруулах (Үр дүн-3)-тай холбогдуулсан үйл ажиллагаа

Үр дүн-3-тай холбогдуулан агаар бохирдуулах эх үүсвэрийн дотроос суурин эх үүсвэрийг бүртгэж хяналт тавих ажлыг хэрэгжүүлсэн.

Суурин эх үүсвэрийн дотроос жилд 50-5,000 тонн нүүрс зарцуулдаг УХЗ-ыг зуухны бүртгэл хяналтын тогтолцоонд хамруулсан. Хяналтын чадавхийг сайжруулах гэдэг нь ялгарлын байдлыг тодорхойлж мэдсэнээр стандарт хангаагүй УХЗ-ны ажиллагааг сайжруулах талаар заавар удирдамж өгч, ажиллагаа нь сайжраагүй зуухны байгууламжийн үйл ажиллагааг хязгаарлан журамлах ажил хийгдэх юм.

Бүртгэлийн тогтолцоонд зуух ашиглалтын зөвшөөрөл олгох 5 зүйлийн шаардлага болзлыг тогтоосон бөгөөд эдгээр шаардлага болзлын дотроос үйл ажиллагаа эрхлэгч байгууллагын хувьд утааны хийн хэмжилт болон утааны хийн стандартыг баримтлуулах шаардлагыг утааны хийн хэмжилтийн зохих тогтолцоо бүрэлдсэний дараа мөрдүүлэхээр түр хойшлуулж, эхний ээлжинд А-д Жил бүр зуухны мэдээллийг ирүүлж байх, В-д зуухны галчийн сургалтанд хамрагдсан байх, С-д зуухны байгууламжид саадгүй нэвтрүүлж, утааны хийн хэмжилтийн хяналт-шинжилгээг хийлгэхийг зөвшөөрсөн харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах зэргийг зуух ашиглах зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага болзол болгосон. Дараа нь эхний өгөгдөл мэдээллийг цуглуулах зорилгоор зуухны байгууламжаар

биечлэн явж судалгаа хийсэн бөгөөд судалгааны дүнд тулгуурлан зуухны бүртгэлийн маягтыг боловсруулж гаргасан.

Тус бүртгэлийн тогтолцоог нэвтрүүлэхдээ үйл ажиллагаа эрхлэгч ААНБ-д шинээр тавигдах журмыг мөрдүүлэхийн тулд хотын Захирагчийн захирамж гаргуулж, мөн Үндэсний Статистикийн Хорооноос статистикийн судалгааны албан ёсны зөвшөөрлийг авсан.

Зөвшөөрөл олгох болзлын нэг болох зуухны галчийн сургалтыг зохион байгуулж, сургалтанд хамрагдсан галч, механикчид батламж олгосон. Утааны хийн хэмжилт зэрэг хяналт-шинжилгээг саадгүй хийлгэхийг зөвшөөрсөн харилцан зөвшилцлийн санамж бичгийн хувьд зуухны бүртгэлийн маягттай цуг тарааж, хамтад нь буцааж хураан цуглуулах аргыг ашиглан бүртгэлд хамрагдах байдлыг сайжруулахыг оролдсон юм.

Зуухны ашиглалтын зөвшөөрөл олгоход МУ-ын “Эрчим хүчний тухай” хуулийн заалттай зөрчилдөх асуудал гарсан тул одоогийн байдлаар “Агаарын тухай” хууль шинэчлэгдэх хүртэл шийдвэрлэх боломжгүй хүлээлгийн байдалтай байгаа. Харин түүний оронд өнөөгийн нөхцөл байдалд үндэслэн утааны хийн стандартыг хангасан, ажиллах орчин сайтай зуухны байгууламжийг сайн ажиллагаатай зуухаар шалгаруулж гэрчилгээ олгох боломжийг судалсан боловч бодитоор хэрэгжүүлэх шатанд хараахан хүрч чадаагүй болно.

1.1.2.4 Агаар бохирдуулах эх үүсвэрт авах арга хэмжээ (Үр дүн-4)-тэй холбогдуулсан үйл ажиллагаа

Үр дүн-4-ийн үйл ажиллагаанд агаар бохирдуулах эх үүсвэрт авах арга хэмжээ болон эрчим хүч дулаан хэмнэлт (ЭХДХ)-ийн үйл ажиллагаатай холбогдсон техникийн ур чадавхийг эзэмшүүлэх, арга хэмжээний саналын жагсаалтыг боловсруулах ажлууд хийгдсэн.

Сургалтын агуулгын хувьд агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний талаарх лекц, дулааны болон зуухны бүтээмжийг хяналт, эрчим хүчний хэмнэлт болон эрчим хүчний оношлогооны багаж хэрэгсэлтэй ажиллаж сурах талаар зааж тайлбарласан. УХЗ-ны галлагаа, ажиллагаанд тавих хяналтын талаарх сургалтанд ашиглах видео хичээлийг бэлтгэж гаргасан бөгөөд үүнийг ашиглан зуухны үйл ажиллагаа эрхлэгч ААНБ-ыг хамруулан хичээл сургалтыг зохион байгуулсан.

Агаарын бохирдлын эсрэг авах арга хэмжээ болон ЭХДХ болон оношлогооны хүрээнд нийлүүлэгдсэн багаж хэрэгслийн хувьд дадлага хийлгэх байдлаар багаж төхөөрөмжийг ашиглах ажиллуулах арга барилыг зааж сургасан. Багаж төхөөрөмжийг үр дүнтэй ашиглахын тулд НАЧА болон ШУТИС-ын хооронд холбогдох хэмжилт, оношлогооны ажилд хэмжилт, оношлогооны багаж төхөөрөмжийг зээлж ашиглаж байх талаар хэлэлцээр байгуулсан.

Арга хэмжээтэй холбогдуулсан үйл ажиллагаанд ДЦС болон УХЗ-нд агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний оношлогоо судалгааг явуулж, арга хэмжээний 16 саналыг гаргасан. Үйлдвэрүүдэд ЭХДХ-ийн оношлогоог хийж, оношлогооны дүнгийн 7 тайлан гаргасан. Хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 23 саналыг боловсруулсан судалгааны дүнд тулгуурлан зууханд авах арга хэмжээний санал болон сайн ажиллагаатай зуухыг шалгаруулахад баримтлах журам стандартын саналыг боловсруулсан.

Төсөл дуусах хүртэл агаарын бохирдлын эсрэг авах арга хэмжээтэй холбоотой нийт 20 гаруй саналыг хэлэлцүүлж холбогдох тэмдэглэлийг боловсруулж гаргасан.

1.1.2.5 Байгаль орчны хяналт, удирдлагын менежмент (Үр дүн 5)-тэй холбогдуулсан үйл ажиллагаа

Байгаль орчны хяналт удирдлагын менежментийн хувьд “Үр дүн 1~4”-ийг нэгтгэн оруулж, агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээний талаарх зөвлөмжийг гаргах (Төслийн зорилго 3) болон төрийн бодлого, хууль эрх зүйн болон бүтэц зохион байгуулалтын орчинг бүрдүүлэх (Төслийн зорилго 4)-эд чиглэсэн үйл ажиллагаа, мэдээлэл сурталчилгааны ажлууд хийгдсэн.

Утааны хийн хэмжилтийн дүн (Үр дүн-2), эх үүсвэрт авах арга хэмжээний судалгааны дүн (Үр дүн-4), тархалтын загварчлалын дүн (Үр дүн-1) –ийн талаар ХЗХ-ны хуралдаан, Х/Т-АХ-ийн уулзалт ярилцлага, байгаль орчны хяналт удирдлагын менежментийн сургалт зэргийн хүрээнд судалж үзэн, авах арга хэмжээний санал зөвлөмжийг боловсруулахаар төлөвлөсөн юм.

Холбогдох байгууллагын бүтэц зохион байгуулалтын тогтолцоог бүрдүүлэхийн хувьд зуухны бүртгэл хяналтын тогтолцоог нэвтрүүлэхтэй холбогдуулан гарсан хотын Захирагчийн захирамжид үндэслэн төслийн явцын үнэлгээний үеэр Төсөл төлөвлөлтийн матриц (ТТМ)-д холбогдох шалгуур үзүүлэлтийг нэмж оруулсан бөгөөд явцын үнэлгээ хийгдсэнээс хойш агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээний саналтай уялдуулан холбогдох байгууллагуудын хооронд санамж бичиг байгуулахаар зорин ажилласан.

Мэдээлэл сурталчилгааны ажлын хүрээнд хотын иргэд болон шийдвэр гаргах түвшиний албан тушаалтанд зориулж төслийн танилцуулга, үйл ажиллагааны мэдээллийн тоймыг бэлтгэн гаргаж, сонинд төслийн үйл ажиллагааны талаар нийтлэл гаргаж, төслөөс гарах үр дүнг нийтэд мэдээлж танилцуулах семинар зэргийг зохион байгуулсан.

Шийдвэр гаргах түвшиний албан тушаалтанд танилцуулахдаа төсөл хэрэгжиж эхлэх үед дугуй ширээний ярилцлага дээр илтгэл тавихаар бодож төлөвлөж байсан хэдий ч эдгээр уулзалт ярилцлага зохион байгуулагдаагүй тул түүний оронд Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооноос зохион байгуулсан хуралдаанд оролцож, илтгэл тавьсан юм.

1.1.3 Төсөл хэрэгжилтийн бодлого

Төслийг хэрэгжүүлэхдээ дараах бодлого, чиглэлийг баримталсан болно.

1.1.3.1 Ур чадавхийн хөгжил

ЖАЙКА байгууллагаас хэрэгжүүлдэг техникийн хамтын ажиллагааны төслүүдийн хувьд ур чадавхийг сайжруулж, бэхжүүлэх явдлыг нийтлэг үзэл баримтлалаа болгодог бөгөөд тус төсөлд монгол талын хамтрагч байгууллагын зохион байгуулалт, боловсон хүчний ур чадавхийг хөгжүүлэх талыг чухалчлан үзсэн.

Тодруулж хэлбэл, төслийн японы мэргэжилтнүүд монголд хийгдсэн судалгааны үр дүнгээ монгол талд тайлан хэлбэрээр тайлагнаж мэдээллэх, агаарын бохирдлын эсрэг авах арга хэмжээний саналыг боловсруулж зөвлөмж болгох зэрэг нь чухал бус харин хамтрагч монгол байгууллагын бүтэц зохион байгуулалт, боловсон хүчний техникийн ур чадавхийг дээшлүүлж сайжруулах, өөрсдийн хүчээр агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг судлан сонгож, хэрэгжүүлэх чадавхийг эзэмшүүлэх явдлыг гол зорилгоо болгосон юм.

Ур чадавхийг эзэмшүүлэхдээ эхний шатанд японы мэргэжилтнүүд тодорхой нэг техникийн ур чадавхийг бодитойгоор хийж үзүүлэн монгол талын хамтрагч мэргэжилтэн, ажилтан нарыг удирдан зааж сургахаас өөр аргагүй байсан хэдий ч аажмаар зөвхөн монгол мэргэжилтнүүд бие даан


хэрэгжүүлж чадахуйц түвшинд хүргэхийг эрмэлзсэн болно. Мөн монгол талын холбогдох салбарын байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох тал дээр тусалж ажилласан.

1.1.3.2 Бохирдлын эх үүсвэрт авах арга хэмжээ

Төслийн эхний жилийн дэлгэрэнгүй төлөвлөгөө боловсруулах судалгааны үеэр 2 талын санал нийлж тохиролцсоны дагуу төслөөс хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд агаарын бохирдлын эсрэг авах арга хэмжээ, ялангуяа бохирдуулах эх үүсвэрт авах арга хэмжээнд гол анхаарлаа чиглүүлэн ажилласан бөгөөд агаар орчны мониторинг явуулах зэрэг ажлууд нь тусгагдаагүй болно (Зураг 1.1-3).

Мөн техникийн хамтын ажиллагааны төсөл болохоор Х/Т болон Х/Т-АХ-ийн гишүүдийг хамруулсан УБ хотын агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээтэй холбоотой чадавхийг хөгжүүлэх (Capacity Development) явдлыг зорилт болгохын зэрэгцээ аль болох хэрэгжүүлэх арга хэмжээтэй шууд уялдуулан холбохыг эрмэлзсэн юм.

Proposed Focus of JICA Technical Cooperation Project for Air Pollution Reduction in UB City



Зураг 1.1-3 Төслийн гол салбар чиглэл

Эх сурвалж : Төслийн эхний жилийн дэлгэрэнгүй төлөвлөгөө боловсруулах судалгааны тайлан тайлангийн зургийг шинэчлэн өөрчилөв.

1.1.3.3 Томоохон болон дунд оврын эх үүсвэр

Тус төслийн үйл ажиллагаанд хамрагдсан бохирдуулах эх үүсвэрийн төрлийг Хүснэгт 1.1-3-д үзүүлэв. ДЦС, УХЗ зэрэг том болон дунд оврын эх үүсвэрт утааны хийн хэмжилт болон хэрэгжүүлэх арга хэмжээний судалгааг хийсэн бөгөөд бусад эх үүсвэрийн хувьд өмнө хийгдсэн судалгааны дүнд тулгуурлан эх үүсвэрийн инвенторыг боловсруулж гаргасан.

Хүснэгт 1.1-3 Төслийн үйл ажиллагаа болон эх үүсвэрийн төрөл

Үйл ажиллагааны агуулга	Эх үүсвэрийн инвентор боловсруулалт, түүний ашиглалт Үр дүн-1, 2				Хэм хэмжээг тогтоох, журамлах чадавхи, авах арга хэмжээний урамшуулал Үр дүн-2, 3				Эх үүсвэрт авах арга хэмжээ Үр дүн-4, 5			Зааж удирдах, сургалт, ЕИС болон хандивлагч байгууллага хоорондын уялдаа холбоо Үр дүн-5		
	Эх үүсвэрийн төрөл	Мэдээллийн технологи тистик	Эх үүсвэрийн тооцоолол	Хэмжилт (Я/К болон үйл ажиллагааны эрчим)	Тархалтын загварчлал	Бүртгэл, Зөвшөөрлийн тогтолцоо	Утааны хийн хэмжилт	Хяналтши нжилгээний туршилт	Гарын авлага болон MNS-ыг сайжруулах санал	Ялгарлыг бууруулах арга хэмжээний санал*	Тогтолцооны боловсронгуй байдал холбогдох сургалт	Зааж удирдах	Сургалт	ЕИС
ДЦС	○	○	○	○	○	○	○	○	○	○	○	○	○	○
Үйлдвэр	○	○	○	○	○	○	○	○	○	○	○	○	○	○
УХЗ	○	○	○	○	○	○	○	○	○	○	○	○	○	○
Бага оврын зуух	○	○	Я/К-ыг судалж тогтоох	○	Хэрэгжүүлэх боломжийг судалж үзэх	Цөөн тооны зуухны хэмжилт	—	Боломжийг судлах	—	—	—	—	—	—
Гэрийн зуух	○	○	Я/К-ыг судалж тогтоох	○	—	Цөөн тооны зуухны хэмжилт	—	Боломжийг судлах	—	—	—	—	—	—
Хөдөлгөөнт эх үүсвэр (утааны хий, автозамын тоос шороо)	○	○	Хэмжилтийн аргыг судалж тогтоох	○	—	—	—	—	—	—	—	—	—	—
Тоос шороо	○	○	—	○	—	—	—	—	—	—	—	—	—	—
Ил задгай шатаах	○	○	—	○	—	—	—	—	—	—	—	—	—	—
Бусад эх үүсвэр	○	○	—	○	—	—	—	—	—	—	—	—	—	—

○:Төсөлд хамрагдсан, —: Төсөлд хамрагдаагүй, *: ЖАЙКА эсвэл бусад хандивлагч байгууллагын хөрөнгө мөнгө, хамтын ажиллагаатай холбоотой


Тус төсөл нь ДЦС болон УХЗ-ыг эн тэргүүнд авч үзсэн бөгөөд гэрийн зуух зэргийн хувьд утааны хийн хэмжилтийн аргыг судалж үзэх зэргээр тодорхой хүрээнд үйл ажиллагааг хязгаарласан юм.

Үүний шалтгаан нь Дэлхийн банк зэрэг бусад хандивлагч байгууллагууд гэрийн зууханд удаан хугацааны туршид хөрөнгө мөнгө гарган судалгаа хийж, авах арга хэмжээг судалж үзсэн байдаг ба мөн хамгийн багадаа 100 мянгаас дээш зуухыг хамруулан судалгаа хийх нь зарцуулагдах хөрөнгө мөнгөтэй харьцуулахад гарах үр дүнгийн хувьд ахиц, үр өгөөж муутай байна гэж үзсэн болно.

Гарах зардал мөнгөтэй гарах үр дүнг харьцуулахад, нүүрсний зарцуулалт болон бохирдуулах бодисын ялгарлын хэмжээны хувьд хамгийн их нь ДЦС байдаг тул төсөлд чухалчлан хамруулах нь зүйтэй гэж үзсэн. Мөн НАЧА болон Х/Т-АХ-ийн гишүүдийн нөөц, ажиллах хүч, УБ хотын хэмжээнд өргөн хүрээг хамрах зэргийг харгалзан үзвэл нийслэлд байгаа 200 гаруй УХЗ-ыг шууд хянаж журамлах нь илүү бодитой үр дүнтэй байх магадгүй юм. Түүний дараа хүчин чадлын хувьд доогуур бага оврын УХЗ нь өмнө хийгдсэн судалгаагаар 1000-аас илүү байна гэсэн дүн гарсан.

1.1.3.4 Хамтрагч тал-Ажлын хэсэг (Х/Т-АХ)-ийн бүрдүүлэлт

Тус төслийн бас нэг гол онцлог нь Х/Т-АХ-ийг бүрдүүлж чадсан явдал юм. (Зураг 1.1-4) Энэ нь өнөөгийн Монгол орны хувьд БО-ны хяналт удирдлагын менежментийн тогтолцоо нь боловсронгуй бус, холбогдох байгууллагын ажлын эрх үүрэг нь хуваагдмал байдалтай байна. Иймд төслийн Х/Т болох Нийслэлийн Агаарын чанары алба (НАЧА) нь дангаараа төслийн биелэлт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй тал байна гэж үзэж байна. Жишээлбэл: УХЗ-нд утааны хийн хэмжилтийг хийхэд НАЧА-нд зуухны байгууламжид нэвтрэн орох, торгууль тавих зэрэг эрх мэдэл байхгүй, харин мэргэжлийн хяналтын газарт эдгээр ажлын эрх мэдэл нь байдаг.



Зураг 1.1-4 Х/Т-АХ-ийн ерөнхий бүдүүвч зураг

Эх сурвалж : Төслийн 2 дах жилийн дэлгэрэнгүй төлөвлөгөө боловсруулах судалгааны тайлан тайлангийн зургийг шинэчлэн өөрчлөв.

1.1.3.5 Бусад хандивлагч байгууллага, ЖАЙКА-ын бусад төсөлтэй хамтарсан ажиллагаа

УБ хотын агаарын бохирдлын эсрэг авах арга хэмжээний хувьд тус төсөл хэрэгжиж эхлэхээс өмнө Дэлхийн банк, Европын Сэргээн босголт, хөгжлийн банк, Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ) (хуучнаар GTZ) зэрэг гадаадын олон хандивлагч байгууллагуудын шугамаар төсөл хэрэгжиж эхэлсэн байсан.


Бусад хандивлагч байгууллагатай байнга холбоотой байж, төслүүд нь хоорондоо үйл ажиллагааны хувьд давхцахгүй байхын тулд харилцан санал бодлоо солилцож, хамтран ажиллах шаардлагатай болсон.

Гадаадын мэргэжилтэн байнга монголд байдаггүй болохоор орон нутгийн ажилтан, мэргэжилтэнтэй холбоо барьж, шаардлагатай үед цахим шуудангаар харилцах, видео хурал хийх зэрэг нь үр дүнтэй гэж үзсэн.

Нийслэлтэй хамтран хэрэгжүүлж буй хот төлөвлөлт, хог хаягдал зэрэг ЖАЙКА-ын бусад төсөлтэй идэвхтэй хамтран ажиллахыг зорьсон бөгөөд төслийн 2 дах жилийн дэлгэрэнгүй төлөвлөгөөг боловсруулах судалгааны дүн шинжилгээнд бохирдуулах бодисын агууламжийн илэрцийн хэмжээг тооцоолохдоо өмнө хэрэгжсэн хот төлөвлөлтийн төслийн судалгааны хүн амын тархалтын өгөгдлийг авч ашигласан болно.

Мөн төслийн зүгээс санал болгох эх үүсвэрт авах арга хэмжээний хувьд ЖАЙКА-ын байгаль орчны хөтөлбөрийн буцалтгүй тусламж, байгаль орчныг хамгаалах хүрээнд 2 үе шаттай хөнгөлөлттэй зээлийг ашиглах зэргийг судалж үзэн, тус төслөөс гарах үр дүнг илүү үр өгөөжтэйгээр ашиглах боломжийг бий болгож, зохицуулах талаар ажилласан.

Тус төслийн бусад хандивлагч байгууллага болон ЖАЙКА-ын бусад төслийн уялдаа холбоог Зураг 1.1-5-д үзүүлэв.



Зураг 1.1-5 Бусад хандивлагч байгууллага болон ЖАЙКА-ын бусад төсөлтэй уялдах байдал

1.1.3.6 УБ хотын онцлог нөхцөл байдлыг харгалзан үзэх

Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний талаас авч үзэхэд УБ хотын хувьд дараах онцлог талууд байсан.

- (1) Өвлийн улирлын хасах 30-40 °C тэсгим хүйтэн болдог цаг уурын нөхцөл байдал
- (2) Өнөөгийн Японы хувьд өмнө нь ашиглаж байсан туршлагаар бага дунд болон бага оврын УХЗ-ыг төсөлд хамруулах
- (3) Нүүрсийг ашиглахаас өөр аргагүй эдийн засгийн болон нийгмийн нөхцөл байдал

Туйлын хүйтэн цаг уурын нөхцөл байдал нь төслийн хэрэгжилт ялангуяа утааны хийн хэмжилт хийхэд ихээхэн нөлөөлж байсан. Техникийн саналд өнөөгийн нөхцөл байдалд хэрэгжиж болохуйц арга хэмжээг судалж үзсэн болно.

Японд эдийн засгийн үсрэнгүй хөгжлийн үед хүчэргүйжүүлэх болон хар тугалгагүй болгох төхөөрөмж суурилуулах зэргээр их хэмжээний хөрөнгө оруулалт хийхийн зэрэгцээ нүүрснээс мазут, байгалийн хийн түлш гаргаж авах зэрэг нь агаарын бохирдлыг бууруулахад ихээхэн үр дүнтэй арга хэмжээ болж байсан. Харин МУ-ын хувьд нүүрсний олборлолт амар, үнэ хямд, ойрын богино

хугацаанд нефть, байгалийн хий гаргаж авах гэсэн сонголт байхгүй болохоор өнөөгийн нөхцөл байдалд хэрэгжүүлж болох бодитой арга хэмжээг судалж үзсэн.

Хоккайдо мужийн Саппоро хотын хувьд өвлийн улиралд халаалтын зориулалтаар ихээхэн хэмжээний нүүрсийг халаалтын зуух болон гэрийн зууханд хэрэглэж байсан гэдгээрээ УБ хотын агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг судлахад тодорхой хэмжээний туршлага, зөвлөгөө болгосон. Мөн хамгийн сүүлд нефтийг түлшинд хэрэглэх болсон нь тоосонцорыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх эцсийн шийдвэрийг гаргахад хүргэсэн бөгөөд түүнээс өмнө ч утаанаас хамгаалах бүс дүүргийг тогтоож, Рингельманы агууламжийн хүснэгтээр ялгарлын агууламжийг тодорхойлж журамлах, өндөр барилгаас тоосонцорыг ажиглан хянаж тортог ялгаруулж буй зуухыг журамлаж хянах зэрэг үйл ажиллагааг явуулж байсан. Японд хэрэгжүүлсэн эдгээр үйл ажиллагаа нь УБ хотын хэмжээнд ялгарлыг бууруулах, журамлах аргачлалыг судалж тогтооход ашиглах боломжтой гэж үзсэн юм.

1.1.3.7 Төсөл төлөвлөлтийн матриц (ТТМ), Хамтарсан Зохицуулах хороо (ХЗХ), төслийн явцын болон эцсийн шатны үнэлгээ

ЖАЙКА байгууллагын техникийн хамтын ажиллагааны төслийн ТТМ -ыг төслийн санааг бодож олох үеэс төслийн саналыг боловсруулах, төлөвлөх болон мониторинг, үнэлгээний үндэс суурь нь болж, төсөл хамтран хэрэгжүүлэгч байгууллага болон холбогдох байгууллага хоорондын санал нийлж тохиролцсон бүтэц бүрэлдэхүүнийг илэрхийлэх хэрэглүүр болгож ашигла сан. ТТМ-ыг төслийн үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлэхэд ашиглахын зэрэгцээ шаардлагатай үед түүнийг шинэчлэн өөрчилж байсан.

ХЗХ-г байгуулах нь ЖАЙКА-ын техникийн хамтын ажиллагааны төслийн хувьд нийтлэг зүйл бөгөөд ерөнхийдөө төслийн удирдагч (тус төслийн хувьд хотын үйлдвэрлэл, экологийн асуудал хариуцсан орлогч дарга) нь ХЗХ-ны даргын үүргийг гүйцэтгэж ажилласан. ХЗХ нь холбогдох салбарын олон тооны байгууллагаас бүрдсэн Х/Т-АХ-ийн үйл ажиллагааг баталгаажуулах үүрэгтэй юм.

Төслийн үйл ажиллагааны явцын үнэлгээ нь төсөл хэрэгжилтийн хугацаа яг талдаа орох үед, харин эцсийн шатны үнэлгээ нь төсөл дуусахаас 6 сарын өмнө тус тус явагсан бөгөөд энэ үед ЖАЙКА-ын төв албанаас үнэлгээний судалгааны баг томилогдон, үнэлгээг хийсэн. Тус төсөлд хэлэлцүүлгийн албан ёсны баримт бичиг (Record of Discussions) үйлдэгдэх үед үнэлгээний ажилд япон талаас гадна монгол талын холбогдох мэргэжилтэнтэй хамтран хамтарсан үнэлгээг хийсэн юм.

1.1.3.8 Японд зохион байгуулагдсан сургалт

Тус төслийн хүрээнд төсөл хэрэгжиж эхэлсэн үеэс утааны хийн хэмжилтийн сургалтанд холбогдох 8 мэргэжилтэнг японд 1 сарын сургалтанд хамруулсан. Иймэрхүү сургалтыг японд зохион байгуулах нь ховор боловч энэ удаа өвлийн улиралд монголд утааны хийн хэмжилт хийх нь техникийн тал дээр нэлээд бэрхшээлтэй байсан тул тохиромжтой орчин, нөхцөл бүрдсэн японд уг сургалтыг зохион байгуулж үндсэн суурь мэдлэг, техникийн ур чадавхийг эзэмшүүлсэн.

Мөн төсөл хэрэгжилтийн 3 жилийн хугацаанд байгаль орчны хяналт удирдлагын менежментийн чиглэлээр жил бүр японд сургалт зохион байгуулах сан бөгөөд эдгээр сургалтанд байгаль орчны хяналт удирдлагын холбогдох байгууллагын мэргэжилтэнг японд урьж ирүүлэн, холбогдох байгууллагын ажилтай танилцуулж, сургалт лекц зохион байгуулахын зэрэгцээ 2 долоо хоногийн сургалтын хугацаанд МУ-ын хувьд тулгамдсан асуудал болж буй агаарын бохирдлыг журамлаж, хяналт тавих асуудалтай холбогдсон даалгаварыг өгч хэлэлцүүлэн, сургалтын төгсгөлд тухайн сэдвээр илтгэл тавиулж байсан.

1.2 Төслийн үр дүнгийн жагсаалт

Хүснэгт 1.2-1-д төслөөс гарах үр дүнг үзүүлсэн бөгөөд төслийн үр дүнгийн хэсэгт хамгийн сүүлд бичигдсэн “нэлээд өндөр” гэдэг нь төслийн эцсийн шатны үнэлгээний багаас өгсөн үнэлгээний үзүүлэлт юм.

Хүснэгт 1.2-1 Төслийн үр дүнгийн жагсаалт

Товч агуулга	Шалгуур үзүүлэлт	Төслийн үр дүн (2012 оны 12 сарын байдлаар)
Эрхэм зорилго		
УБ хотын агаар бохирдуулах бодисын ялгарлыг бууруулахад чиглэсэн бодлогын хэрэгжилтийг сайжруулах.	1. 150-200 гаруй УХЗ болон гурван ДЦС зэрэг УБ хотод байрлах агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэрийг бүртгэн хянаж, ялгарлын стандартын шаардлагыг хангуулах	
Төслийн зорилго		
Нийслэлийн болон бусад холбогдох байгууллагын боловсон хүчний ур чадавхийг сайжруулахад голлон анхаарч, УБ хотын агаарын бохирдолд авах арга хэмжээний хэрэгжилтийн явц, ур чадавхийг сайжруулан бэхжүүлэх	1. НАЧА нь бусад холбогдох байгууллагатай хамтран төсөл хэрэгжилтийн хугацаанд жилийн ажлын тайланд дор хаяж 2 удаа эх үүсвэрийн инвенторын тооцооллын дүн, агаар орчны үнэлгээний дүн болон ялгарлын хэмжилтийн дүнг оруулж тайлагнах.	Эхний удаа 2012 оны 6 сард 2010 оны байдлаарх бохирдуулах эх үүсвэрийн инвентор, агаар орчны үнэлгээний дүн болон утааны хийн хэмжилтийн дүнг, 2 дах удаад 2012 оны 12 сард 2011 оныхыг тус бүр боловсруулан гаргаж, НАЧА-ны жилийн ажлын тайланд оруулан тайлагнасан болно. Үйл ажиллагааны хэрэгжилтийн биелэлтийг нэлээд өндөр түвшинд байна гэж үнэлсэн.
	2.НАЧА нь бусад холбогдох байгууллагатай хамтран төсөл хэрэгжих хугацаанд жилийн тайландаа үндэслэн агаарын бохирдолд авч явуулах арга хэмжээний талаар 5 саналыг боловсруулан гаргаж, УБ хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчын ажлын албаны даргад өргөн барьж, зөвлөмж болгох	Төслийн япон мэргэжилтний багаас агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээтэй холбогдуулан 11 санал зөвлөмжийг гаргасан бөгөөд түүнээс 3 саналын хувьд НАЧА болон Х/Т-АХ-ийн хүчин чармайлтын дүнд НИТХ-иар батлагдаж үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан. Үлдсэн арга хэмжээний саналын хувьд цаашид НАЧА нь бусад холбогдох байгууллагатай хамтран хэлэлцэж судалж үзсэний үндсэн дээр хотын орлогч даргад танилцуулж санал болгохоор төлөвлөж байна. Үйл ажиллагааны хэрэгжилтийн биелэлтийг

		өндөр түвшинд байна гэж үнэлсэн.
	3. НАЧА нь бусад холбогдох байгууллагатай хамтран, төслийн хугацаанд хийгдэх бүх дугуй ширээний ярилцлага болон бусад уулзалт ярилцлагаар төсөл хэрэгжилтийн явцын дүнг тайлагнан танилцуулах.	Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооноос зохион байгуулсан хандивлагч байгууллага болон монгол талын байгууллагын хамтарсан хуралдаанд оролцож, НАЧА болон япон мэргэжилтэн нь төслийн үйл ажиллагааны талаар танилцуулж, 2012 оны 10 сард Х/Т нь төслийн үр дүнд үндэслэсэн илтгэлийг тавьсан. Үйл ажиллагааны хэрэгжилтийн биелэлтийг нэлээд өндөр түвшинд байна гэж үнэлсэн.
	4. Хотын Захирагчийн захирамж гаргуулах зэргээр албан ёсны төрийн бодлого, ажлын хүрээнд шийдвэрлүүлэх эсвэл НАЧА болон төр, нийслэлийн хэмжээний холбогдох байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтын талаар хэлэлцээр бичгийг байгуулах зэргээр агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг идэвхтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн төрийн бодлогын болон хууль эрх зүйн, мөн бүтэц зохион байгуулалтын ажлын хүрээг тогтоож бүрдүүлэх”	Зуухны бүртгэл хяналтын тогтолцоог нэвтрүүлэхтэй холбогдуулан хотын Захирагчийн захирамжийг 2011 оны 8 сард гаргуулж, мөн 2012 оны 11 сард НАЧА болон ШУТИС-ийн хооронд агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээ болон ЭХДХ-ийн оношлогооны багаж төхөөрөмжийг ашиглахтай холбогдсон санамж бичгийг байгуулсан. Цаашид холбогдох байгууллага тус бүрийн ажлын үүрэг хариуцлага, хувиарлалтын талаар санамж бичиг байгуулах зэргээр албан ёсны бүтэц зохион байгуулалт, ажлын уялдаа холбоог сайжруулах талаар судалж байгаа болно. Үйл ажиллагааны биелэлтийн байдлыг дунд түвшинд гэж үзсэн. Шалгуур үзүүлэлт 1-ээс 4 хүртэлх үйл ажиллагааны биелэлтээс төслийн зорилго биелэгдэх магадлалыг нэлээд өндөр гэж үнэлсэн.
Үр дүн		
Үр дүн-1	НАЧА болон холбогдох байгууллагын агаарын бохирдлын эх үүсвэрийг судлан шинжлэх, агаарын орчны үнэлгээний ур чадавхийг сайжруулах.	2012 оны 11 сар хүртэлх 2 удаа мэдээллийн санг шинэчилж, инвенторын гарын авлагыг боловсруулж гаргасан. Тархалтын загварчлалын моделийг боловсруулж дуусгаж, эх үүсвэр тус бүрт нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх арга хэмжээг судалж үзэн, цаашид НАЧА болон холбогдох байгууллагууд хоорондоо хэлэлцүүлэг хийж, судалж үзсэний дүнг хотын орлогч даргад танилцуулах төлөвлөгөөтэй байна. Үйл

		ажиллагааны биелэлтийн байдлыг нэлээд өндөр гэж үнэлсэн.
Үр дүн-2	УБ хотын утааны хийн хэмжилтийг цаашид тогтвортой үргэлжлүүлэн хийх	<p>ДЦС-ын зуух, УХЗ, гэрийн зууханд нийт 201 удаа утааны хийн хэмжилт хийж, төлөвлөсний дагуу техникийн ур чадавхийг эзэмшүүлж, утааны хийн хэмжилтийн техникийн гарын авлагыг боловсруулж гаргасан. Цаашид сайн ажиллагаатай зуухыг тогтоож, нийтэд танилцуулж мэдээллэх ажлыг явуулахаар судалж байна.</p> <p>Үйл ажиллагааны биелэлтийн байдлыг нэлээд өндөр гэж үнэлсэн.</p>
Үр дүн-3	Холбогдох байгууллагатай хамтран, НАЧА-ны ялгарлын хэм хэмжээг тогтоож журамлах ур чадварыг сайжруулах	<p>2011 оны 8 сард хотын Захирагчийн захирамж гарч, мөн онд зуухны бүртгэл хяналтын тогтолцоог албан ёсоор нэвтрүүлсэн. Зуухны бүртгэлийн маягтыг боловсруулж гарган, мэдээллийн санг байгуулж, түүнд тулгуурлан бохирдуулах эх үүсвэрийн инвенторыг боловсруулсан. Зуухны бүртгэл хяналтын тогтолцооны талаарх танилцуулга хурал болон зуухны галчийн сургалтыг зохион байгуулсанаар хяналт удирдлагын тал болон үйл ажиллагаа эрхлэгч тал хоорондын ажлын уялдаа холбооны тогтолцоог бий болгосон. Цаашид тус тогтолцоог бүрэн цогцоор нь амжилттай хэрэгжүүлэх арга замыг тодорхой болгох шаардлагатай байгаа юм.</p> <p>Үйл ажиллагааны биелэлтийн байдлыг нэлээд өндөр гэж үнэлсэн.</p>
Үр дүн-4	НАЧА нь агаарыг бохирдуулах бодисын эх үүсвэрт авах арга хэмжээг санаачлан гаргах	<p>ДЦС болон УХЗ-ны хувьд арга хэмжээний 16 санал гаргасан бөгөөд 7 үйлдвэрт эрчих хүч дулаан хэмнэлтийн оношлогооны дүнг тайлагнасан. УХЗ-ны галлагаа, ажиллагааны баримтлах горим, зарчмын талаарх сургалтын материалыг боловсруулж гаргасан. ДЦС, үйлдвэр, УХЗ-ны үйл ажиллагаа эрхлэгч байгууллагатай зуухны утааны хийн хэмжилтийн сорьцын цэг суурилуулах, шаталтыг сайжруулахад чиглэсэн бодлогын талаар хэлэлцүүлэг явуулж, өнөөг хүртэл 10 хурлын тэмдэглэл, протоколыг эмхтгэн гаргасан ба төсөл дуусах хүртэл нийт 20 гаруй протокол, тэмдэглэлийг үйлдэж гаргахаар төлөвлөж байна.</p> <p>Үйл ажиллагааны биелэлтийн байдлыг нэлээд</p>

		өндөр гэж үнэлсэн.
Үр дүн-5	НАЧА болон холбогдох байгууллага нь гарах үр дүн 1-4 ийг нэгтгэн, агаарын бохирдлын хяналт, удирлагын менежментэд тусган, мэдээллийг нийтэд мэдээллэх боломжтой болох.	Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооноос зохион байгуулсан хандивлагч байгууллага, монгол талын холбогдох байгууллагын уулзалт хуралдаанд төслийн явцыг танилцуулж, төслийн товч агуулгыг бичсэн мэдээллийн тоймыг боловсруулан гаргаж, НАЧА-ны цахим хуудсанд гаргадаг жилийн ажлын тайланд нийтлэн, энэ талаар танилцуулах семинарыг зохион байгуулсан. Нөгөө талаар цаашид шийдвэр гаргагч түвшиний албаны хүмүүс болон иргэдэд мэдээллийг хүргэх талаар ажил хийх шаардлагатай байна. Үйл ажиллагааны биелэлтийн байдлыг нэлээд өндөр түвшинд гэж үнэлсэн.

Зохистой байдал, үр дүнтэй байдал, үр өгөөжтэй байдал, нөлөөлөл болон тогтвортой байдал гэсэн үнэлгээний 5 үзүүлэлтийн дагуу дараах үнэлгээ хийгдсэн.

(1) Зохистой байдал	Төслийн зорилго нь Япон улсын монгол улсад үзүүлэх тусламжийн бодлого, агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний талаарх монгол улсын төрийн бодлогын чиг хандлагатай сайн нийцсэн байгаа. Агаарын бохирдлын эсрэг авах арга хэмжээг хэрэгжүүлэх чадавхийн хөгжлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн байгаа. Японы агаарын бохирдлын эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээний техникийн ур чадавхи, туршлагыг чухалчлан тэдгээрийг ашиглах чиг хандлагатай болсон. Төслийн хамарсан хүрээ нь бусад хандивлагч байгууллагын хэрэгжүүлж буй төслийн үйл ажиллагаатай давхцахгүй байхыг анхаарсан зохистой байдлаар төлөвлөгдсөн байгаа. Үйл ажиллагааны зохистой байдал өндөр.
(2) Үр өгөөжтэй байдал	Төслийн хүрээнд техникийн ур чадавхи эзэмшүүлсэнээр Х/Т болон Х/Т-АХ-ийн гишүүдийн утааны хийн хэмжилт хийх болох өгөгдөлд дүн шинжилгээ хийх ур чадавхи сайжирсан. Төслийн хүрээнд агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний 11 саналыг судалж үзэж байгаа бөгөөд НАЧА болон ХТ-АХ-ийн гишүүдийн идэвх чармайлтын дүнд эдгээр саналаас 3 санал нь НИТХ-аар батлагдан, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан байгаа. Цаашид НАЧА болон холбогдох байгууллагууд үлдсэн арга хэмжээний биелэгдэх боломжийн талаар судалж үзэх бөгөөд ерөнхийд нь агаарын бохирдлыг хянах чадавхийг сайжруулахад чиглэсэн бүтэц зохион байгуулалт, уялдаа холбоог бий болгоход илүү анхаарч улам идэвхийлэн ажиллах шаардлагатай байна. Үйл ажиллагааны үр дүнтэй байдал нэлээд өндөр түвшинтэй байна.
(3) Үр дүнтэй байдал	Явцын үнэлгээ хийгдэх үед гол шаардлагатай багаж төхөөрөмжийн нийлүүлэлт хоцорсоноос төслийн үйл ажиллагааны явцад нөлөөлсөн гэж үзсэн бөгөөд түүний дараа Х/Т болон япон мэргэжилтэн нь сургалт, ажлын байрны дадлага,

	<p>семинар болон ажил хэргийн хуралдааныг тогтмол явуулсанаар нөлөөллийг багасгах талаар идэвхийлэн ажилласан. Төрийн эрх барих хүчин өөрчлөгдсөн хэдий ч төлөвлөсөн үйл ажиллагааг бараг хэрэгжүүлсэн. Японд 3 удаа холбогдох сургалтыг зохион байгуулагдсан бөгөөд 12 сард төлөвлөж байсан сургалт нь Х/Т болон Х/Т-АХ-ийн гишүүдийн төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэхэд дэмжлэг өгөх зорилгоор зохион байгуулагдсан юм. НАЧА-ны ажилтаны боловсон хүчний шилжилт, өөрчлөлт нь цөөрч, мэргэжилтэн шинээр авсан. Хөрөнгө оруулалтын хувьд зохистой ашиглалтын үр дүнг бий болгосон. Х/Т-АХ-ийн байгууллагын уялдаа холбоог бий болгоход төлөвлөснөөс илүү их цаг хугацаа шаардагдсан. Үйл ажиллагааны үр дүнтэй байдал нь нэлээд өндөр.</p>
(4) Нөлөөлөл	<p>“УБ хотын агаар бохирдуулах бодисын ялгарлыг багасгахад чиглэсэн бодлогын хэрэгжилтийг сайжруулах” гэсэн төслийн эрхэм зорилгын биелэлтийн байдал дунд зэрэг гэж үзсэн. Эрхэм зорилгыг биелүүлэхийн тулд Х/Т-тай холбоотой шийдвэр гаргах түвшиний албан тушаалтаны үйл ажиллагааны чанар, хэмжээг сайжруулж хангалттай түвшинд хүргэж, найдвартай өгөгдөл мэдээлэлд тулгуурласан бодитой зөвлөмжийг гаргах ур чадавхийг сайжруулах, шаардлагатай хууль эрх зүйн тогтолцоог боловсруулж, агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний хэрэгжилтэнд хувь нэмэр оруулах шаардлагатай юм. НАЧА болон холбогдох байгууллага нь цаашид ур чадавхийг тогтвортой хөгжүүлэн бэхжүүлж чадвал төслийн эрхэм зорилго биелэгдэх магадлалтай юм. Үйл ажиллагааны нөлөөллийн байдлыг нэлээд өндөр гэж үзсэн.</p>
(5) Тогтвортой байдал	<p>Тогтвортой байдал нь төсөл дууссанаас хойш төслийн үр дүн нь тогтвортой хэрэгжих эсэхийг судлах явдал юм. МУ-ын төрийн бодлого нь агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээнд чиглэсэн болохоор төрийн бодлогын хувьд тогтвортой байдал өндөртэй гэж үзэж байна. Гэвч байгууллагын бүтэц зохион байгуулалтын тогтолцооны талаас Х/Т болон Х/Т-АХ хоорондын уялдаа холбоог сайжруулах шаардлагатай юм. Техникийн ур чадавхийн тогтвортой байдал нь утааны хийн хэмжилтийн хувьд тогтвортой хөгжлийн байдал өндөр байгаа хэдий ч тархалтын загварчлалын модель, агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг судлах, ЭХДХ-ийн оношлогооны үйл ажиллагааны тогтвортой байдлыг сайжруулахад илүү дэмжлэг тусламж үзүүлэх шаардлагатай юм. Үйл ажиллагааны тогтвортой байдал нь дунд зэрэг гэж үнэлэгдсэн.</p>

Эцэст нь эдгээр холбогдох үнэлгээнээс дараах дүгнэлтийг гаргасан болно.

1. Үйл ажиллагаа нь ерөнхийдөө төлөвлөгөөны дагуу хэрэгжиж байгаа.
2. Төслийн зорилго биелэгдэх магадлал нэлээд өндөр байгаа.
3. Техникийн ур чадавхи эзэмшүүлэх ажил, хамтын ажиллагаа цаашид үргэлжлүүлэн явуулах шаардлагатай байгаа.
4. Дараах зөвлөмжийг дагаж цаашид үйл ажиллагаандаа тусган ажиллавал төслийн зорилго болон эрхэм дээд зорилгыг биелүүлэх магадлал нэмэгдэх болно.

1.3 ТТМ-ын өөрчлөлт

2009 оын 12 сарын 21-ны RD-д гарын үсэг зурж батлагдсан ТТМ (Version 1)-ын хувьд 2011 оын 1 сарын 5 –нд (Version 2), 2011 оны 12 сарын 2-нд (Version 3) болгож нийт 2 удаа өөрчлөлт оруулсан юм.

Version 2 -т RD-ын үед шийдвэрлэгдэж тогтоогүй байсан “Үр дүн 4”-ын “НАЧА нь агаарыг бохирдуулах бодисын эх үүсвэрт авах арга хэмжээг санаачлан гаргах” –ад чиглэсэн үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт 4.1-ын санааг нарийн тодорхойлон зааж, авах арга хэмжээний хувьд “20 санал” боловсруулж гаргахаар зааж өгсөн.

Version 3-т төслийн зорилгод 4 дэх шалгуур үзүүлэлт болгон ”Хотын Захирагчийн захирамж гаргуулах зэргээр албан ёсны төрийн бодлого, ажлын хүрээнд шийдвэрлүүлэх эсвэл НАЧА болон төр, нийслэлийн хэмжээний холбогдох байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтын талаар хэлэлцээр бичгийг байгуулах зэргээр агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг идэвхтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн төрийн бодлогын болон хууль эрх зүйн, мөн бүтэц зохион байгуулалтын ажлын хүрээг тогтоож бүрдүүлэх” гэсэн зүйлийг нэмсэн. Мөн төслийн зорилгын шалгуур үзүүлэлт 3-т төслөөс гарсан үр дүнг тайлагнах дугуй ширээний уулзалт ярилцлага болон түүнтэй дүйцэхүйц хэмжээний уулзалт ярилцлага гэсэн өгүүлбэрээс “бүх” гэсэн үгийг хассан.

ТТМ (Version 1, Version 2, Version 3) –ыг Хавсралт материал 1.3-1-т үзүүлэв.

1.4 Хамтарсан зохицуулах хорооны хуралдаан зохион байгуулалт

Төсөл хэрэгжих хугацаанд нийт 7 удаа Хамтарсан зохицуулах хороо (ХЗХ)-ны хуралдааныг зохион байгуулсан. Тэдгээр хуралдааныг зохион байгуулсан хугацаа болон гол агуулгыг Хүснэгт 1.4-1-т үзүүлэв. Мөн хуралдаан тус бүрийн хурлын протокол тэмдэглэлийг Хавсралт материал 1.4-1-т үзүүлэв.

3 дах болон 7 дах удаагийн ХЗХ-ны хуралдаан дээр “Бие дааж тогтвортой хөгжих нөхцлийг хангах матриц” нь холбогдох олон тооны байгууллагаас бүрдсэн Х/Т-АХ-ийн оролцоотойгоор хэрэгжсэн тус төслийн хувьд гарах үр дүн, төслийн зорилгыг биелүүлж, төсөл дууссаны дараах холбогдох байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог хангаж бүрдүүлэх явдлыг зорилгоо болгосон юм. Матрицыг ерөнхийд нь ” 1. Төслөөс гарах үр дүнгийн бие дааж тогтвортой хөгжих хүчин зүйлийг тодорхойлох матриц” болон ” 2.Төслийн үр дүнд хамаарах Х/Т-АХ-ийн холбогдох байгууллагын ажлын хувиарлалт, үүрэг оролцооны хэлбэрийг судлах матриц” гэж хуваасан.

Эхний матрицын хувьд үр дүн болон төслийн зорилгод хүрэхэд чиглэсэн шат дарааллыг техникийн ур чадавхи эзэмшүүлсэн боловсон хүчнээр хангах, ур чадавхийг бэхжүүлж сайжруулах, түүнийг ашиглах байдлыг хангах, тоног төхөөрөмж болон байгууламж зэрэг ажиллах орчныг бүрдүүлэх, тэдгээрийн ашиглалтын хяналт, мэдээллийн сан суурыг бүрдүүлж, ашиглалтанд хяналт тавих, ажлын гүйцэтгэл, чанарын хяналт, байгууллагыг боловсон хүчнээр хангах, төсөв бүрдүүлэлт, байгууллагын бүтэц, зохион байгуулалтын тогтолцоог бүрдүүлэх, байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах, АБ-ын эсрэг авах арга хэмжээг сонгон шийдвэрлэх, мөн хэрэгжүүлэх механизмыг бий болгох гэсэн хүчин зүйлүүдийн хүрээнд авч үзсэн.

2 дах матрицын хувьд үр дүн болон төслийн зорилгыг биелүүлэхэд чиглэсэн холбогдох байгууллага хоорондын ажлын хувиарлалт, үйл ажиллагааны үндсэн чиглэлийн хүрээнд авч үзсэн юм.

Мөн 3 дах удаагийн ХЗХ-ны хуралдааны үеэр авч хэлэлцсэн “Бие дааж тогтвортой хөгжих нөхцлийг хангах матриц”-ыг Хавсралт материал 1.4-2-д, 7 дах удаагийн хуралдааны үеэр хэлэлцэж яригдсан матрицын агуулгыг Хавсралт материал 1.4-3-д тус тус үзүүлэв.

Хүснэгт 1.4-1 ХЗХ-ны хуралдааны тэмдэглэл

Хурал, семинар, ажил хэргийн хуралдаан болон сургалтын нэр	Явагдсан огноо	Гол агуулга
1 дэх ХЗХ-ны хуралдаан	2010.04.15	<p>Судалгааны тайлангийн танилцуулга, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Х/Т-АХ-ийн гишүүд болон оролцогчдын жагсаалтыг баталсан.</p> <p>Мөн удахгүй японд зохион байгуулахаар төлөвлөж байсан утааны хийн хэмжилтийн сургалтанд хамрагдах хүмүүсийг сонгон шалгаруулах зааварчилгааг нарийвчлан гаргаж шийдвэрлэсэн.</p>
2 дах ХЗХ-ны хуралдаан	2011.01.05	<p>Явцын тайлан-1-ыг баталсан. ТТМ-д агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний хувилбарын тоог 20 гэж тогтоосон. .</p> <p>Мөн монгол тал нь тархалтын загварчлалыг ихээхэн сонирхож, ДЦС зэрэгт авах арга хэмжээг судалхад чухал үүрэг гүйцэтгэх утааны хийн хэмжилтийн дүнг холбогдох байгууллага хүмүүст гаргаж өгөхийг хүссэн.</p>
3 дах ХЗХ-ны хуралдаан	2011.09.23	<p>Явцын тайлан-2-ыг баталсан. Зуухын бүртгэл хяналтын тогтолцоог нэвтрүүлэх талаар хэлэлцүүлэг явагдсан.</p> <p>Япон мэргэжилтний хувьд ДЦС-тай орчны бохирдлоос хамгаалах тухай хэлэлцээр байгуулж, хяналт тавьж ажиллахыг зөвлөсөн. Монгол тал нь УХЗ-ыг төвлөрсөн системд оруулах санал тавьсан бөгөөд мэргэжилтний зүгээс ч энэ арга хэмжээг дэмжиж санал нийлсэн.</p> <p>ЖАЙКА байгууллагын мэргэжилтэн нь монгол талд хандан ДЦС 2 болон 3 нь цаашид оршин тогтнох эсвэл хаагдах талаар тодорхой байр сууриа илэрхийлэх нь зүйтэй гэж онцлон тэмдэглэсэн.</p> <p>Төслийн үр дүнгийн цаашид бие дааж тогтвортой хөгжих нөхцлийг хангах матрицын талаар тайлбарлаж, хэлэлцүүлэг явагдсан.</p> <p>ХЗХ-ны дарга дэлгэрэнгүй нарийвчилсан матрицын дагуу хийгдсэн дүн шинжилгээг сайшааж, монгол талын холбогдох байгууллага, албаны хүмүүсийг энэ тал дээр анхаарч, зохих бүтэц, зохион байгуулалтын шинэчлэлт хийхийг уриалсан.</p>
4 дэх ХЗХ-ны хуралдаан	2011.12.02	<p>Явцын үнэлгээний дүнгийн тайланг баталгаажуулсан. Зуухны бүртгэл хяналтын тогтолцооны явцын байдлыг тайлагнасан.</p> <p>Бусад хандивлагч байгууллагууд хэрэгжүүлээгүй байсан УХЗ-ны утааны хийн хэмжилтийн дүн, шинжлэх ухааны үндэслэлтэй өгөгдлийг олж чадсаныг чухал</p>

		<p>ач холбогдолтой гэж хамтарсан үнэлгээний багаас үнэлж, онцлон тэмдэглэсэн.</p> <p>Дэлхийн банкны семинарт утааны хийн хэмжилтийн дүнгийн талаар илтгэл тавьсан бөгөөд ЭХЯ-ны мэргэжилтнээс тус хэмжилтийн дүнг хэвлэл мэдээллээр нийтэд мэдээллэх нь зүйтэй гэсэн санал дэвшүүлж байсан.</p>
5 дах ХЗХ-ны хуралдаан	2012.10.22	<p>Явцын тайлан-3-ыг баталсан. .</p> <p>ЦУОШГ-ын төсөлд оролцогч гишүүнээс РМ10-ын тархалтын загварчлалын дүн нь суурин харуулын хэмжилтийн дүнтэй зөрүүтэй байгааг учир шалтгааныг талаар асуулт тавьж, энэ талаар тархалтын загварчлалыг хариуцсан төслийн япон мэргэжилтэн байж болох магадлалын талаар тайлбарласа.</p>
6 дах ХЗХ-ны хуралдаан	2012.12.07	<p>Эцсийн шатны үнэлгээний дүнгийн тайланг баталсан. Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний саналын танилцуулга, хэлэлцүүлэг явагдсан.</p> <p>ЖАЙКА-ын төв албаны ажилтан нь АБ-ын эсрэг авах арга хэмжээний талаар Х/Т болон Х/Т-АХ-ийн хүрээнд хэлэлцүүлэг явуулж, хотын орлогч дарга болон АББҮХ-нд танилцуулах ажил хийхийг хүссэн. Мөн монгол талаас төслийн II үе шатыг хэрэгжүүлэх талаар хүсэлт тавьж, өмнө хэрэгжиж эхлээд байгаа Дэлхийн банкны төсөл болон тус төслөөс харилцан уялдуулсан үр дүнг гаргах талаар зохицуулж ажиллах бодолтой байгаа талаар ярьсан.</p>
7 дах ХЗХ-ны хуралдаан	2013.02	<p>Төслийн эцсийн тайлангийн саналын танилцуулга, хэлэлцүүлгийг явуулж, энэ талаарх санал бодлоо гаргах хугацааг зааж өгсөн. Мөн төсөл дуусаж байгаатай холбогдуулан төслийн мэргэжилтний зүгээс цаашид шийдвэрлэх шаардлагатай асуудлын талаар илтгэл тавьсан. Хуралдааны төгсгөлд олон улсын хамтын ажиллагааны мэргэжилтэнээс цаашдын үйл ажиллагааны зохион байгуулалт, төсөл болон тэдгээрийг хамруулсан нөхцөл байдлын талаар санал бодлоо илэрхийлсэн.</p>

1.5 Төслийн тайлангийн тэмдэглэл

Хүснэгт 1.5-1-т төслийн тайлан гарсан болон батлагдсан хугацааг үзүүлэв.

Хүснэгт 1.5-1 Төслийн тайлангийн тэмдэглэл

Тайлангийн нэр	Гаргасан хугацаа	Батлагдсан хугацаа
Судалгааны тайлан	2010 оны 4 сар	2010 оны 5 сар
Явцын тайлан-1	2010 оны 12 сар	2011 оны 1 сар (2 дах удаагийн ХЗХ-ны хуралдаан)
Явцын тайлан-2	2011 оны 6 сар	2011 оны 9 сар (3 дах удаагийн ХЗХ-ны хуралдаан)
Явцын тайлан-3	2012 оны 6 сар	2012 оны 10 сар (5 дах удаагийн ХЗХ-ны хуралдаан)
Эцсийн тайлангийн төсөл Техникийн гарын авлагын санал	2013 оны 1 сар	2013 оны 2 сар
Эцсийн тайлан Техникийн гарын авлага	2013 оны 3 сар	-

1.6 Техникийн гарын авлага болон ажиллагааны зааварчилгаа

Төслийн хүрээнд боловсруулж гаргасан техникийн гарын авлагыг Хүснэгт 1.6-1-т үзүүлэв. Тус төсөлд техникийн ур чадавхийн талаар тайлбарласан агуулга бүхий материалыг “Гарын авлага”, ажиллах горим зарчмын талаар тайлбарласан материалыг “Ажиллагааны зааварчилгаа” гэж нэрлэсэн болно. Гарын авлагыг тусгайлан хэвлэж, тараасан.

Хүснэгт 1.6-1 Техникийн гарын авлагын жагсаалт

Салбар, чиглэл	Гарын авлагын нэр
Утааны хийн хэмжилт	Утааны хийн хэмжилтийн стандарт, горим Утааны хийн хэмжилтийн үндсэн зарчим, голлох хэмжилтийн утгыг хэрхэн авч үзэх, параметр тус бүрийн тооцооллын арга зэрэг хэмжилтийн үндсэн аргачлалын онолын талаар тайлбарласан болно.
	Сорьцын цэгийг суурилуулах зааварчилгаа Төслийн хүрээнд утааны хийн хэмжилт хийхийн тулд зуухны яндан болон утааны сувагт хэмжилтийн сорьцын цэгийг суурилуулах шаардлага болон түүнийг суурилуулах арга (холбогдох зураг схемьг оруулан)-ын талаар тайлбарласан.
	Утааны хийн химийн анализ шинжилгээний дээж авалт, анализ шинжилгээний зааварчилгаа Уусмалын аргаар агаар бохирдуулах бодисын агууламжийг хэмжих зорилгоор дээж авах арга болон авсан дээжийг лабораторт шинжилж, анализ хийх аргын талаар тайлбарласан.
	ДЦС-ын утааны хийн хэмжилтийн зааварчилгаа ДЦС-т утааны хийн хэмжилтийн стандарт, үндсэн горимын дагуу ажиллах талаар дэлгэрэнгүй тайлбарласа.
	УХЗ, гэрийн зуухны утааны хийн хэмжилтийн зааварчилгаа УХЗ болон гэрийн зууханд утааны хийн хэмжилт хийх стандарт, үндсэн горимын дагуу ажиллах талаар дэлгэрэнгүй тайлбарласан.
Зуухны бүртгэл хяналт	Зуухны бүртгэл, хяналтын тогтолцооны гарын авлага Тус тогтолцооны танилцуулга, зуухны бүртгэлийн маягтын агуулга, мэдээллийн сангийн функцийн талаар тайлбарласан.
Эх үүсвэрийн инвентор	Эх үүсвэрийн инвенторыг боловсруулах, шинэчлэх гарын авлага Эх үүсвэрийн инвентор гэдэг ухагдахуунаас эхлээд УБ хотын эх үүсвэрийн инвенторын тодорхой байдал, агаар бохирдуулах бодисын ялгарлын хэмжээний тооцооллын аргын талаар тайлбарласан.
Тархалтын загварчлал	Тархалтын загварчлалыг боловсруулж, шинэчлэх гарын авлага Тархалтын загварчлалын моделийг гаргах, түүний үүрэг функцийн талаар тайлбарлахын зэрэгцээ УБ хотын хэмжээнд боловсруулж гаргасан тархалтын загварчлалын дүнг танилцуулсан.

2 Үйл ажиллагааны товч танилцуулга

2.1 Агаар бохирдуулах эх үүсвэрийн дүн шинжилгээ, агаар орчны үнэлгээний чадавхийг бий болгох (Үр дүн 1)

2.1.1 Үр дүн 1-тэй холбоотой техникийн үр чадавхи эзэмшүүлэлт (семинар, ажил хэргийн хуралдаан зэргийг багтаах)

2.1.1.1 Зуухны бүртгэл, зөвшөөрөл олгох тогтолцоо болон эх үүсвэрийн инвентортой холбоотой ажил хэргийн хуралдаан (2010 оны 6 сарын 25 өдөр)

Япон болон Монголд зуухны бүртгэл, зуух ашиглах зөвшөөрөл олгох тогтолцоо болон эх үүсвэрийн инвенторын талаар ажил хэргийн хуралдааныг зохион байгуулсан. Монгол тал нь эх үүсвэрийн инвентор болон зуухны бүртгэлийн тогтолцооны харилцан уялдаа холбооны талаар хангалттай ойлголтгүй байсан тул ажил хэргийн хуралдаан зохион байгуулах зэргээр энэ чиглэлээр ойлголт, мэдлэг өгөх тал дээр ажиллаж энэ нь техникийн үр чадавхи эзэмшүүлэх үйл ажиллагаатай уялдан хэрэгжсэн болно.

2010 оны 6 сарын 25 өдөр явагдсан ажил хэргийн хуралдааны материалыг Хавсралт материал 2.1-1-т үзүүлэв.

Явагдсан огноо : 2010 оны 6 сарын 25-ны өдөр (Баасан) 10:00~14:05

Явагдсан газар : Puma Imperial Hotel

1. Нээлт

10:00-10:05 Openings by Chultemsuren BATSAIKHAN, AQDCC

2. Зуухны бүртгэл, ашиглах зөвшөөрлийн тогтолцоо

10:05-10:25 Presentation on boiler registration system in Japan by Mr. Masanori EBIHARA (Boiler Technology for Air Pollution Control 2)

10:25-10:45 Presentation on boiler registration in Mongolia Mr. Ts. MUNKHBAT (Ministry of Nature, Environment and Tourism, Office of Environmental Pollution)

10:45-11:45 Discussions on Boiler Registration and Permission System

11:45-12:00 Coffee Break

3. Эх үүсвэрийн инвентор

12:00-12:20 Presentation on stationary source inventory in Japan by Mr. Toru TABATA (Stationary Source Inventory / Simulation 1)

12:20-12:40 Presentation on mobile source inventory in Japan by Mr. Hiroyuki MAEDA (Mobile Source Inventory)

12:40-13:00 Presentation on emission source inventory in Mongolia by Ms. Sarangerel ENKHMAA (National Agency for Meteorology and Environment Monitoring)

2.1.1.2 Эх үүсвэрийн инвентор болон тархалтын загварчлалын тухай ажил хэргийн хуралдаан (2011 оны 3 сарын 4 өдөр)

Эх үүсвэрийн инвентор болон тархалтын загварчлалыг гаргах тухай ажил хэргийн хуралдааныг зохион байгуулсан бөгөөд энэ үеэр 2011 оны 2 сарын байдлаарх УБ хотын суурин болон хөдөлгөөнт эх үүсвэр, бусад эх үүсвэр, тархалтын загварчлалын дүнг тайлагнаж, холбогдох салбарын байгууллагуудтай мэдээллээ хуваалцаж, санал бодлоо солилцсон.

2011 оны 3 сарын 4 өдөр зохион байгуулагдсан хуралдааны материалыг Хавсралт материал 2.1-2-т үзүүлэв.

Огноо : 2011 оны 3 сарын 4 өдөр (Баасан) 10:00-13:00

Газар : Монгол-Японы төв

Хөтөлбөр

10:00~10:05 Нээлт (НАЧА)

10:05~10:25 Эх үүсвэрийн инвентор гэдэг нь? (Табата)

10:25~10:55 Суурин эх үүсвэрийн инвенторын талаар (Табата)

10:55~11:20 Хөдөлгөөнт эх үүсвэр, бусад эх үүсвэрийн инвентор, агаар бохирдуулах бодисын нийт ялгарлын хэмжээний талаар (Маэда)

11:20~11:35 Тархалтын загварчлалын дүнгийн талаар (Табата)

11:35~11:50 Үдийн завсарлага

11:50~12:50 Эх үүсвэрийн инвентор болон тархалтын загварчлалын талаарх хэлэлцүүлэг

12:50~12:55 Дүгнэлт

12:55~13:00 Хаалт

2.1.1.3 Инвентор, тархалтын загварчлалын тухай сургалт (2 дах жилийн)

Инвентор, тархалтын загварчлалын сургалтыг ЦУОШГ-ын сургалтын танхимд Хүснэгт 2.1-1-т үзүүлсэн хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан. Сургалтанд 15 хүн оролцсон бөгөөд тархалтын загварчлалын моделийг боловсруулж гаргахын тулд цаг уурын өгөгдөл болон агаар орчны өгөгдөл дүн шинжилгээ хийх, модельд оруулах өгөгдлийг боловсруулах арга, моделийн дүнгийн үнэлгээний аргын талаар голчлон зааж, оролцогчдод инвенторын өгөгдлийн шинэчлэл, тархалтын загварчлалын моделийг дахин боловсруулахад шаардагдах техникийн ур чадавхи болон ноу-хаут эзэмшүүлсэн. Инвентор, тархалтын загварчлалын сургалтын байдлыг Зураг 2.1-1-т үзүүлэв. Тус сургалтанд ашигласан

материалыг Хавсралт материал 2.1-3-т үзүүлэв.

Хүснэгт 2.1-1 Сургалтын агуулга болон хөтөлбөр

Огноо	Суурин эх үүсвэр	Хөдөлгөөнт болон бусад эх үүсвэр	Тархалтын загварчлал
